

## ЗЭСИЙН БАЯЖМАЛ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

<b>ТӨСЛИЙН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ</b>	
1. Төслийн нэр, хүчин чадал:	Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр. Жилд 120 мянган тонн катодын зэс үйлдвэрлэнэ.
2. Төсөл хэрэгжих салбар, дэд салбар:	Хүнд үйлдвэрийн салбар. Өнгөт төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл
3. Төслийн хэрэгжих хугацаа:	2016-2019 он
4. Төслийн хөрөнгө оруулалт /сая ам.доллар/:	798,8
5. Хэрэгжүүлэгч яам, байгууллага:	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
<b>ТӨСЛИЙН ТАЛААРХ НАРИЙВЧИЛСАН МЭДЭЭЛЭЛ</b>	
6. Бүтээгдэхүүн:	Төслийн хүрээнд жилд 530.0 мянган тн. зэсийн баяжмалыг боловсруулж 120 мян.тн катодын зэс, 200 мян.тн хүхрийн хүчил, 110мян.тн элементийн хүхэр тус тус үйлдвэрлэнэ.
7. Төслийн үндэслэл:	<p>-Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлын 2010 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор Монгол Улсад зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулахаар шийдвэрлэсэн.</p> <p>-Улсын Их Хурлын “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай” 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 41 дүгээр тогтоолын 10.4 дэх заалтад Зэс хайлуулах үйлдвэрийг барьж байгуулахад шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэхээр тусгасан.</p> <p>-Монгол Улсын Засгийн газрын “Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийг байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай” 2015 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн 247 дугаар тогтоол.</p> <p>-Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр.</p> <p>-Монгол Улсын Засгийн газрын “Төслийн нэгж байгуулах тухай” 2016 оны 09 дүгээр сарын 28 –ны өдрийн 107 дугаар тогтоол.</p>
8. Төслийн зорилго:	Монгол Улсын зэсийн нөөцөд тулгуурлан цэвэр зэс үйлдвэрлэх, зэсээр хийсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх үндэс суурийг тавихад төслийн үндсэн зорилго оршино.

<p>9. Төслийн техникийн баримт бичиг боловсруулсан байдал:</p>	<p>Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн Техник-эдийн засгийн үндэслэлийг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн захиалгаар БНХАУ-ын Өнгөт металлургийн үйлдвэрийн зураг төслийн институт /ENFI/ боловсруулж, 2015 оны 7 дугаар сарын 9-ны өдрийн Аж үйлдвэрийн яамны шинжлэх, технологийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, дэмжигдсэн.</p>
<p>10. Хүрэх үр дүн:</p>	<ul style="list-style-type: none"> <li>-Монгол улс дотооддоо үйлдвэрлэсэн зэс, түүгээр хийсэн бүтээгдэхүүнээр өөрийгөө бүрэн хангаж, эцсийн бүтээгдэхүүн экспортлогч орон болно.</li> <li>- Тухайн үйлдвэрийг дагалдан туслах үйлдвэрүүд, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч жижиг, дунд үйлдвэрлэл хөгжинө.</li> <li>-Үйлдвэрлэлд байгаль орчин, нийгэмд аюулгүй техник, технологи нэвтэрнэ.</li> <li>-Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрээс техник технологи, ажлын байр, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартуудыг эзэмшсэн, дотоод, гадаадын хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөхүйц дадлага туршлагатай ажиллах хүчин бий болно.</li> <li>-Их дээд сургууль болон техник мэргэжлийн сургуулиудын сургалтын хөтөлбөр шинэчлэгдэж, шинэ төрлийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх тогтолцоо бүрдэнэ.</li> <li>-Экспортын болон импортыг орлох бүтээгдэхүүний нэр төрлийг шинээр бий болгосноор манай улсын гадаад худалдааны тэнцэлд эзрэг нөлөө үзүүлнэ.</li> <li>-Орон нутагт 759 шууд ажлын байр шинээр бий болгоно.</li> </ul>